



ШИНЭ ҮЕ СУРГУУЛЬ /CAS 2021/

ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



## IB CAS хөтөлбөр

**“Нийгэмд тустай ажил” хичээлийн  
эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан  
гарын авлага**



Шинэ Үе Сургууль  
2021 он

## **Ай Би хөтөлбөрийн эрхэм зорилго**

*Ай Би хөтөлбөр нь мэдлэг чадвартай, сонирхон судалдаг, хүн төрөлхтний өв уламжлал, ёс заншил, хэл соёлыг хүндлэн дээдэлж эх дэлхийн энх тайвныг эрхэмлэдэг, илүү сайхан ертөнцийг бүтээж чадах шинэ залуу үеийг бэлдэхийг эрхэм зорилгоо болгодог. Бид олон улсын байгууллага, засгийн газруудтай хамтран ажиллаж, олон улсын жишигт нийцсэн боловсролын хөтөлбөр боловсруулж, шударга, нягт шалгах үнэлгээний аргачлалыг улам бүр хөгжүүлсээр байна. Энэхүү хөтөлбөрөөр суралцаж буй хүүхэд бүр идэвхтэй, хүсэл тэмүүлэлтэй, хүн бүрийн онцлог зан чанарыг ойлго. хүндэтгэж чаддаг, насан туршдаа сурч боловсрох чадвартай иргэн болон төлөвшдөг.*

## **Шинэ Үе сургуулийн эрхэм зорилго**

*Бид шинэ үеийнхнийг*

*Халамжтай*

*Хариуцлагатай*

*Хүнлэг*

*Хичээнгүй*

*Эрүүл чийрэг*

*Эрдэм боловсролтой*

*Эх хэл өв уламжлалаа хайрлан хамгаалдаг*

*Энэ дэлхийн улс үндэстэн бүрийн ёс заншил ахуй соёлыг хүндлэн дээдлэх иргэн болгож төлөвшүүлнэ.*

IB дипломын хөтөлбөрийн зохицуулагч: Т.Ханджав

Утас: +976 91117811

Цахим шуудан: [khandjav@shineue.edu.mn](mailto:khandjav@shineue.edu.mn)

Оффис: Шинэ үе сургууль, Сүхбаатар дүүрэг, UNESCO гудамж-12, АйБи Оффис

IB CAS-ийн зөвлөгч багш: Б.Молор-Эрдэнэ

Утас: +976 88700938

Цахим шуудан: [boldbaatar.m@shineue.edu.mn](mailto:boldbaatar.m@shineue.edu.mn)

Оффис: Шинэ үе сургууль, Сүхбаатар дүүрэг, UNESCO гудамж-12, АйБи Оффис

## “Ай Би” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар

Эх дэлхийгээ энх тайван байлгаж, одоо байгаагаас нь илүү сайхан ертөнцийг бий болгохын тулд хүнлэг чанараа танин мэдэж, энэ дэлхий ертөнцийг хамгаалах хамтын үүргээ ухамсарлан ойлгох чадвартай олон улсын сэтгэлгээтэй хүмүүс болгон хөгжүүлэхэд “Ай Би” хөтөлбөрийн эрхэм зорилго оршино.

### **“Ай Би ” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар:**

**СОНИУЧ** Өөрсдийн сонирхсон зүйлсээ лавлан асуух, судлан шинжлэх чадвартай, аливаа зүйлд тэмүүлэлтэй, үргэлж суралцаж, хөгжих чадвартай иргэн болон төлөвшдөг.

**МЭДЛЭГТЭЙ** Тэд бүс нутагтаа болон олон улсад тулгамдсан асуудлын ойлголт, санаануудыг нээн олж чаддаг. Үүний үр дүнд тэрхүү ойлголт, санаа, асуудлынхаа талаар өргөн болоод тэнцвэртэй ойлголттой болж, гүн гүнзгий мэдлэг олж авч чаддаг. Олон талын мэдлэгтэй, түүнийгээ амьдралд хэрэглэх чадвартай иргэн болж төлөвшдөг.

**СЭТГЭН БОДОГЧ** Нарийн төвөгтэй асуудлуудад дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй шийдвэр гаргахдаа шүүмжлэлт бүтээлч сэтгэлгээний чадварыг ашигладаг. Энэ нь тэднийг илүү хэрсүү ухаантай болгон хөгжүүлдэг.

**ХАРИЛЦАГЧ** Бусадтай илүү нээлттэй өөртөө итгэлтэй харилцаж, бусдыг ойлгож, анхааралтай сонсож тэдэнтэй хамтран ажиллах чадвартай иргэн болон төлөвшдөг.

**ЗАРЧИМЧ** Аливаа зүйлд зарчимч, шударга ханддаг, ёс зүйтэй, хууль дүрмийг чанд сахидаг, хүмүүсийн нэр төр ба эрхийг хүндэтгэж, өөрсдийн үйлдэл, тэдгээрийн үр дагавруудад хариуцлага хүлээж чаддаг иргэн болж төлөвшдөг.

**НИЙТЭЧ** Өөрсдийн соёл, бусдын үнэт зүйлс, уламжлалыг хүндэлж, бодитойгоор үнэлэн дүгнэдэг, юмсыг олон талаас харах чадвартай, туршлагаасаа суралцаж өсөн дэвжихэд бэлэн байдаг иргэдийг бэлддэг.

**ХАЛАМЖТАЙ** Өөрсдийгөө бусдын оронд тавьж, бусдыг энэрч, хүндэтгэдэг, бусдын амьдрал болон хүрээлэн буй орчинд эерэг өөрчлөлт авч ирж чаддаг иргэн болон төлөвшдөг.

**ЭРСДЭЛ ҮҮРЭГЧ** Аливаа тодорхойгүй зүйлд шийдэмгий хандаж, шинэ шинэлэг санааг судлахын тулд бие даан болон хамтран ажиллах чадвартай, сорилт бэрхшээл, өөрчлөлтийн өмнө бэлэн зогсож чаддаг, хөрвөх чадвар сайтай иргэн болон төлөвшдөг.

**ТЭНЦВЭРТЭЙ** Өөрсдийн болон бусдын сайн сайхан зүйлсийн төлөө оюун ухаан, бие бялдар, болон сэтгэл хөдлөл зэрэг амьдралынхаа янз бүрийн төлөвийг тэнцвэржүүлэхийн чухал ач холбогдлыг ойлгодог, бусад хүмүүс болон амьдарч буй ертөнцтэйгөө харилцан хамааралтайгаа хүлээн зөвшөөрдөг уян хатан иргэн болон төлөвшдөг.

**ЭРГЭЦҮҮЛЭГЧ** Аливаа зүйлсийн мөн чанарыг эргэцүүлэн бодож, юмсын сайн муу, үнэн зөвийг ялган таньж ухаалгаар шийдвэрлэж чаддаг.

## Агуулга

CAS-ийн талаар товчхон	5
CAS-ийн гурван хэлхээ	9
CAS хөтөлбөрийн суралцахуйн долоон зорилт	11
CAS-ийн ажлын таван үе шат	12
Эргэцүүлэмж ба Нотолгоо	14
Эцсийн хугацаа	17
CAS-ийн төсөл	19
Чиглүүлэх асуултууд	20
CAS-ийн туршлага болон төсийн жишээ	21
CAS хөтөлбөрийн суралцагчийн CAS-ийн хувийн хэрэг	22
CAS-ийн ярилцлага	22
CAS хөтөлбөрийн суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг	24
CAS хөтөлбөрийн суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай хийх гэрээ	25
CAS reporting timelines	26
A student checklist for CAS	28
CAS project form	30
CAS portfolio checklist	32
Ашигласан материалын жагсаалт	33

## CAS-ийн талаар товчхон

*“... Хэрвээ чи итгэж л байвал, бодох, ярих, бичих бус,  
харин үйлдлээрээ гүйцэтгэ.”*

*(Петерсон, 2003 он)*

“CAS нь дипломын хөтөлбөрийн цөм юм. CAS нь PYP (Бага ангийн хөтөлбөр)-өөс MYP (Дунд ангийн хөтөлбөр) хүртэл цогц арга барилаар сурагчийн бие хүний ба нийгмийн харилцааг бэхжүүлэх, өргөжүүлэх зорилготой юм.

CAS нь бүтээлч ажил (цаашид “Creativity” гэх), бие махбодийг хөгжүүлэх ажил (цаашид “Activity” гэх), сайн дурын ажил (цаашид “Service” гэх) гэсэн гурван хэлхээний хүрээнд зохион байгуулагддаг бөгөөд дараах байдлаар тодорхойлогддог.

- **Creativity** — ямар нэгэн шинэ санаа санаачилгыг хөгжүүлэх эсвэл сайжруулах ажил
- **Activity** — эрүүл амьдралын хэв маягт зориулан бие махбодийг хөгжүүлэх дасгал хөдөлгөөн
- **Service** — бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан сайн дурын тусламжийн үйл ажиллагаа зохиох, хамтран ажиллаж, харилцан туслалцах

CAS-ийн хөтөлбөр нь сурагчдад АйБи суралцагчийн хувийн шинж чанарыг бодит, практик байдлаар харуулах, өвөрмөц хувь хүн болж төлөвших, бусадтай харилцаа хамааралтай байх өөрсдийн үүрэг, байр суурийг танин мэдэх боломжийг олгодог. Сурагчид өөрсдийн сонирхлыг эрэлхийлэх, хүсэл тэмүүлэл, зан чанар, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг олгодог хувь хүн, бүлэглэлийн олон талын туршлагаар дамжуулан ур чадвар, хандлага, зан төлөвөө хөгжүүлдэг. CAS-ийн хөтөлбөр нь хүнд хэцүү академик хөтөлбөрийг цогц байдлаар нөхөж, өөрийгөө тодорхойлох, хамтран ажиллах, амжилтад хүрэх, сэтгэл ханамж авах боломжийг олгодог. (Нийгэмд тустай ажил хичээлийн гарын авлага, 2017 он, хуудас 8)

**Creativity, activity, service (CAS)** нь суралцагчийн чадварыг сайжруулах, хөгжүүлэх зорилго бүхий сонирхолтой, чадвар сорьсон үйл ажиллагааны цогц юм. CAS-ийн үйл ажиллагаанд оролцсоноор дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

1. Өөрийнхөө давуу талууд ба хөгжүүлэх шаардлагатай талуудыг танин мэдэх
2. Үйл ажиллагааны явцад тулгарах сорилтуудыг даван туулснаар шинэ чадварууд эзэмших ба хөгжүүлэх
3. CAS-ийн үйл ажиллагааг хэрхэн төлөвлөх, зохион байгуулахыг харуулах
4. CAS-ийн үйл ажиллагаандаа тууштай оролцож байгаагаа харуулах
5. Бусадтай хамтран ажиллах чадвар, түүний ач холбогдлыг ойлгож мэдэх
6. Дэлхий нийтэд ач холбогдол бүхий асуудлуудад оролцоогоо харуулах
7. Сонгосон сонголт, хийсэн үйлдээ ёс зүйг баримтлах

***CAS хөтөлбөр нь дипломын хөтөлбөрийн академик сургалтын ачааллыг тэнцвэржүүлдэг:***

1. Суралцагчдад шинэ үүрэг, шинэ сорилттой тулгарах сонирхлыг нь төрүүлдэг.
2. Суралцагчдыг илүү эргэцүүлэн бодогч зан чанартай болгодог.
3. Суралцагчид өөрсдийгөө хүрээлэн буй орчин болон бие биенийхээ өмнө хариуцлага хүлээх нийгмийн нэгээхэн бүрэлдэхүүн хэсэг гэдгийг ухаардаг.

4. Суралцагчид хамтарсан, урт хугацаанд үргэлжилсэн төслүүдэд идэвхтэй оролцдог.

### **Бүтээлч үйл ажиллагаа (Creativity)**

Энэ хэсэгт ямар нэгэн шинэ санал санаачилгыг хөгжүүлэх эсвэл сайжруулах ажил хийнэ. Жишээ нь:

1. Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан аудио ном бүтээх, кино зохиол бэлдэх
2. Хэрэгцээтэй байгаа хүмүүст нь зориулж гадаад хэл заах, эсвэл технологи ашиглан гадаад хэл сурах гарын авлага бичих, сайжруулах, эсвэл вебсайт эсвэл бусад төрлийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан суралцаж буй гадаад хэл, соёлын талаар бусдын анхаарал татахуйц үйл ажиллагаа зохион байгуулах
3. Өндөр настны асрамжийн газар байгаа хүмүүсийн амьдралын түүхийг сонсож, тэдний ярьсан зүйлсийг бичлэг болгон гэр бүлд нь дурсгах, нийгэмд тулгамдаж буй асуудалд туслах зорилгоор нийгэмлэг байгуулах эсвэл олон нийтийн цэцэрлэгт хүрээлэнд сайн дураар туслах
4. Бага болон дунд ангийн суралцагчдад зориулж одон орныг судлах клуб ажиллуулах
5. Хөгжим тоглодог хүүхэд ая зохиох, зураг зурдаг хүүхэд фото зургийн үзэсгэлэн гаргах, баримал хийх гэх мэт үйл ажиллагаа явуулах
6. Жүжигт тоглох дуртай хүүхэд жүжиг найруулах, зохиох эсвэл олон нийтийн театрын клубд нэгдэх
7. Сургууль дээр ямар нэг клуб ажиллуулах
8. Хоолны дамжаанд суралцах
9. Вебсайт хөгжүүлэх
10. Өрхийн сарын орлогын зарцуулалтыг хянах сорилт зохион байгуулах
11. Цуврал хөрөг зургууд зурах, сийлбэр хийх гэх мэт.

### **Өөрийн бие махбодийг хөгжүүлэх ажил (Activity)**

1. Эрүүл амьдралын хэв маягт зориулан дасгал хөдөлгөөн хийх, бие мах бодийг хөгжүүлэх сургалт зохион байгуулах
2. Ганцаарчилсан болон багийн спортоор хичээллэх
3. “Сургуульдаа явганаар ирэх алхалтын клуб” байгуулах
4. Аеробикийн дасгал хийх эсвэл булчин хөгжүүлэх дасгал хийх
5. Бүжгээр хичээллэх
6. Ууланд авирах
7. Бусад суралцагчидтай хамтран спортын дугуйлан хичээллүүлэх, хичээллэх /гүйлтийн клуб, теннисний клуб гэх мэт/
8. Явган аялал хийх
9. Цанаар гулгаж сурах гэх мэт

### **Сайн дурын ажил (Service)**

1. Бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан тусламжийн үйл ажиллагаа зохиож хүмүүстэй хамтран ажиллаж, харилцан туслалцах
2. Байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад туслах үйл ажиллагаа зохион байгуулах
3. Математикийн хичээлээр сурлагын хоцрогдолтой байгаа хүүхдүүдэд хичээл заах эсвэл математик бодит байдал дээр өдөр тутмын амьдралд ямар байр суурь эзэлдгийг мэдрүүлэхийн тулд математикийн хичээлээр Scavenger hunt уралдаан зохион байгуулах
4. Тоглолтод бэлтгэж бүжиг, жүжгийн хичээл заах, уран зургийн эсвэл фото зургийн үзэсгэлэнд оролцох, зохион байгуулах.
5. Малын хашаанд ажиллах
6. Цэцэрлэгт хүрээлэнд ажиллах, мод тарих, жимс тарих, арчлах
7. Ашгийн бус байгууллагын вебсайтыг шинэчлэн өгөх
8. Хэл заахын тулд бодит зурагтай ном бүтээх
9. Ялгаварлан гадуурхлалтын эсрэг жүжиг тоглох
10. Олон нийтийн газарт хог хаях явдлыг бууруулах зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх
11. Сургуулийн орчинд сургалт явуулах гэх мэт.



## CAS-ийн гурван хэлхээ



→ ***IB удирдамжийн дагуу, БҮТЭЭЛЧ АЖИЛ гэдэг нь "урлаг уран сайхан, бүтээлч сэтгэлгээ шаардсан бусад туршлагыг" хэлнэ.***

Энэ ажлын хүрээнд, таны хүүхэд сонин бичиж эхлүүлэх, кино хийх, бүжиг дэглэх, театрт жүжиг найруулах, жүжиглэх, хөгжмийн зэмсэг тоглож сурах, шинэ гадаад хэл сурах, хөгжмийн уран бүтээлд оролцох эсвэл бага насны сурагчдад зааж сургах боломжтой.

→ ***БИЕ МАХБОДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АЖИЛ гэдэг нь "Дипломын хөтөлбөрт сурч боловсрохын зэрэгцээ эрүүл амьдралын хэв маягийг бүрдүүлэхэд чиглэсэн бие бялдын хүчин чармайлт шаардсан ажил" юм.***

Энэ ажлын хүрээнд, таны хүүхэд спорт, бүжиг, бие даан бэлтгэл хийх, холын зайн гүйлтэд оролцох, экспедицэд явах, цасны цанаар гулгах гэх мэт экстрим спортоор хичээллэх зэрэг үйл ажиллагаанд оролцож сайн дурын ажилдаа зориулж сан үүсгэх боломжтой.

→ ***САЙН ДУРЫН АЖИЛ гэдэг нь "суралцагч шинэ зүйл сурах боломжтой, ямар нэгэн цалин хөлс авдаггүй, сайн дурын солилцооны ажил юм. Сайн***

***дурын ажил хийснээр суралцагч өөрийн эрх, нэр төр, бие даасан байдал, хүндлэл зэргийг ухаарч ойлгодог.”***

Энэ нь ТББ, орон нутгийн эсвэл дэлхийн олон нийтийн байгууллага эсвэл нийгмийн бизнес эрхлэх төсөл хөтөлбөрт хамрагдах замаар хүрээлэн буй нийгэмдээ сайн дурын ажил хийх гэсэн үг юм. Үүний гол утга учир нь зөвхөн бусдын төлөө бус харин бусадтай хамт ажиллах юм.

### **Бүтээлч ажил, бие махбодийг хөгжүүлэх ажил, сайн дурын ажлын боломжууд**

Сурагчид оролцож болох олон боломжийн талаар бодоход туслах дараах зөвлөмжүүд байна. Сурагчид CAS-ийн туршлагын шаардлагад нийцэх эсэх нь эргэлзээтэй байвал өөр олон боломжуудын талаар CAS-ийн зохицуулагчтайгаа ярилцах боломжтой. Зарим ажлууд хоёр эсвэл гурван CAS-ийн хэлхээг агуулах боломжтой.

#### ***Creativity***

- Шатрын клуб
- Найрал дуу
- Мэтгэлцээний баг
- Сургуулийн сонин, сэтгүүл
- Хөгжмийн зэмсгийн хичээл (өөрөө сурах эсвэл бусдад заах)
- Веб хуудас хөгжүүлэх
- Фотошоп програм заах
- Юм нэхэх гэх мэт

#### ***Activity***

- Бөхийн барилдааны тэмцээн
- Зохион байгуулалттай ямар нэг спортын багт орох
- Зохион байгуулалттай алхах, гүйх, ууланд авирах, дугуй унах
- Иогийн хичээлд өөрөө суралцах эсвэл бусдад заах

- Орчин үеийн эсвэл сонгодог эсвэл баллетийн бүжгийн хичээлд өөрөө суралцах эсвэл бусдад заах
- Булчин хөгжүүлэх дасгал хөдөлгөөн төлөвлөгөөтэйгөөр, зорилготойгоор хийх
- Бие хамгаалах урлагт суралцах, эсвэл бие хамгаалах спортын төрлөөр хичээллэх гэх мэт

### **Service**

- Байгаль орчны цэвэрлэгээ
- Ашгийн төлөө бус зуны зусланд сайн дураар ажиллах
- Эмнэлэгт сайн дураар ажиллах
- Орон нутгийнхаа эсвэл нийтийн номын санд сайн дураар ажиллах
- Тэтгэвэрт гарсан эсвэл өндөр настай хүмүүсийг асрах
- Дунд эсвэл бага сургуульд сайн дураар багшлах гэх мэт

## **CAS хөтөлбөрийн суралцахуйн долоон зорилт**


CAS-ийн удирдамжийн дагуу бүх CAS-ийн ажил дор жагсаасан долоон зорилтоос дор хаяж гурвыг багтаасан байх ёстой. Энэ нь сурагчдад зорилтуудыг анхааралтай уншиж, тэдний хийж эхлэхийг хүсч буй төсөл/туршлагад аль нь хамаарах вэ гэдгийг шийдэхийг зөвлөдөг. IB-ийн дипломын хөтөлбөрийн хоёр жилийн хугацаанд CAS хөтөлбөрийн шаардлагыг бүрэн хангахын тулд бүх долоон зорилтод хүрэх ёстой. Зарим нь олон янзын үйл ажиллагаануудад олон удаа давтагдах боловч төгсгөлд нь зорилтуудад хүрснээ батлан үзүүлэх хэд хэдэн нотолгоотой байх шаардлагатай. Сурагчид явцын эсвэл эцсийн эргэцүүлэмжээ бичихдээ зорилтуудыг нь үргэлж дурдаж, хэрхэн зорилтод хүрч байгаагаа тодорхой жишээ, баримт нотолгоогоороо харуулах ёстой.

### ***CAS хөтөлбөрийн суралцахуйн долоон зорилтод:***

- 1. STRENGTHS AND GROWTH.** Өөрийн давуу талыг ухамсарлан ойлгож, хөгжүүлэх шаардлагатай талуудаа мэдэж авах

2. **CHALLENGE AND SKILLS.** CAS-ийн сургалтын явцад сорилтыг давж, шинэ чадваруудад суралцсан гэдгээ харуулах
3. **INITIATIVE AND PLANNING.** CAS-ийн аливаа ажлыг хэрхэн төлөвлөж явуулж болохыг харуулах
4. **COLLABORATIVE SKILLS.** Хамтран ажиллахын ач холбогдлыг ойлгож, хамтран ажиллах чадвараа харуулах
5. **COMMITMENT AND PERSEVERANCE.** CAS-ийн үйл ажиллагааг зохион явуулах тэвчээр хатуужилтай байж үйлдлээрээ харуулах
6. **GLOBAL ENGAGEMENT.** Дэлхий нийтэд ач холбогдолтой үйл ажиллагааг зохион байгуулж, оролцож байгаагаа харуулах
7. **ETHICS OF CHOICES AND ACTIONS.** Сонголт болон үйл хөдлөлийнхөө үр дагаврыг ухаарах, хариуцах

### **CAS-ийн ажлын таван үе шат**



## **CAS-ийн үйл ажиллагааг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:**

- 1. Ажиглан судлах:** Суралцагчид өөрсдийнхөө сонирхол, авьяас чадвар, хөгжүүлэх шаардлагатай талуудаа танин мэдэх зорилгоор CAS-ийн ажлаа сонгон авна. Суралцагчид CAS-ийн ажлынхаа зорилго, юу хийхийг хүсч байгаагаа тодорхойлно. Сайн дурын ажил /service/ хэсэгт хамаарах ажил зохион байгуулахдаа тухайн ажлыг хийх ямар хэрэгцээ байгааг тайлбарлах шаардлагатай.
- 2. Бэлдэх:** Сурагчид үүрэг, хариуцлагаа тодорхой болгож, хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг боловсруулж, боломжит нөөц бололцоо, цаг хугацааг тодорхойлж, CAS-ийн туршлагаа гүйцэлдүүлэхэд шаардлагатай бүх ур чадварыг судалж мэдсэн байна.
- 3. Үйл хөдлөл болгох, гүйцэтгэх:** Суралцагчид шийдвэр гаргах болон асуудал шийдвэрлэх чадвараа ашиглан өөрсдийн санаа эсвэл төлөвлөгөөгөө бие даан, хосоор эсвэл багаар хамтран хэрэгжүүлнэ.
- 4. Хийсэн ажил, туршлагынхаа талаар эргэцүүлэмж бичих:** Суралцагчид юу болсон, юу хийсэн, ямар сэтгэгдэл төрсөн зэргээ дүрслэн бичсэнээр шинэ санаа, асуултууд урган гарна. CAS-ийн үйл ажиллагааны аль ч шатанд төлөвлөгөөгөө дахин нягтлах, туршлагаасаа суралцах, хувь хүний хөгжил, ололт амжилт хоёрын хоорондын холбоо, үр дүнг тодорхой болгохын тулд эргэцүүлэмж бичих ба энэ нь сурагчийг дараа дараагийн аливаа шинэ үйл ажиллагааг эхлэхэд ч хүргэж болзошгүй юм.
- 5. Баталгаа, нотолгоо үзүүлэх:** Суралцагчид сурсан, хийсэн зүйлүүдээ нотолж харуулна. Жишээ нь: CAS-ийн туршлагаа CAS-ийн хувийн хэргээрээ дамжуулан албан ба албан бус байдлаар бусад суралцагчдад үзүүлснээр суралцагчид өөрсдийн ойлголтоо бататгаж, бусдадаа сэтгэгдэл төрүүлнэ.

## **Эргэцүүлэмж ба Нотолгоо**

### **Эргэцүүлэмжийн шинж чанар**

“Эргэцүүлэмж бол өөрийгөө танин мэдэх, суралцах, шийдвэр гаргахад чиглэсэн хүчтэй хэрэгсэл юм. CAS-ийн эргэцүүлэх үйл явцад дөрвөн эх үүсвэр нөлөөлдөг.” (Нийгэмд тустай ажил хичээлийн гарын авлага, 2017 он, хуудас 26)

### ***Эхний хоёр эх үүсвэр нь эргэцүүлэмжийн суурийг бүрдүүлдэг. Үүнд:***

- ❑ Юу болсныг дүрслэх: сурагчид өөрт дурсамжтай мартагдашгүй мөчөө эргэн дурсаж, юу нь чухал эсвэл өөрийн бодолд нөлөөлж байсан, юу нь сайн болсон эсвэл хэцүү байсан, мөн ямар бэрхшээлийг даван туулж амжилтад хүрснээ дүрслэн бичнэ.
- ❑ Мэдрэмжээ илэрхийлэх: сурагчид тухайн CAS-ийн ажилд оролцох явцад ямар мэдрэмж төрсөн талаар илэрхийлэн бичнэ.

### ***Удаах хоёр эх үүсвэр нь илүү эрч нэмж, хэтийн зорилтыг өргөжүүлэн тэлдэг. Үүнд:***

- ❑ Тунгаан бодох: сурагчид өөрийн хийсэн сонголт болон үйлдэл нь өөрт болон аливаа нөхцөл байдалд хэрхэн нөлөөлж буйг тунгаан бодож бичнэ.
- ❑ Асуулт асуух: сурагчид тухайн CAS-ийн ажилд оролцох явцад уулзсан хүмүүс, болсон ямар нэгэн үйл явдал, мөн тулгарсан асуудлын талаар ул суурьтайгаар бодож бичнэ.

### **Эргэцүүлэмжээ дэлгэрүүлэх нь**

Оюун санааны дөрвөн эх үүсвэрийн талаарх үр дүнтэй ойлголтыг бий болгосноор сурагчид бодол санаа, мэдрэмж, үйл хөдлөлийг шүүмжлэлтэйгээр шалгаж, сурч мэдсэн зүйлээ нэгтгэн дээд төвшний сэтгэх чадварыг хөгжүүлдэг. Мэдлэгийн онол (ТОК) хичээл нь сурагчдад эргэцүүлэмжээ хөгжүүлэх, өргөжүүлэх, шүүмжлэлтэй сэтгэх чадварыг эзэмшүүлдэг. Жишээлбэл, Мэдлэгийн онол

хичээлийн үеэр тэд өөрсдийн сэтгэл хөдлөл, үндэслэлтэйгээр сэтгэх чадвар, аливаа хэлийг хэрхэн ашиглах талаар хэлэлцдэг.

Эргэцүүлэмжийн хамт CAS-ийн зохицуулагч ба/эсвэл зөвлөгчийн санал сэтгэгдлийг сонсох нь үр дүнтэй бөгөөд зайлшгүй шаардлагатай байдаг. Санал сэтгэгдэл нь албан бус эсвэл албан ёсны хэлэлцүүлгийн хэсэг гэх мэт олон хэлбэртэй байж болно. Сурагчид мөн ямар арга хэлбэрээр зөвлөгөө, санал сэтгэгдэл авахыг хүсч буй талаараа санал болгож болно. Жишээ нь: Имэйлээр, репортоор, ганцаарчлан уулзаж гэх мэт.

### **Эргэцүүлэмжийн хугацаа**

Сурагчид CAS-ийн туршлага бүрийн дараа эргэцүүлэмж бичих шаардлагагүй; тэд эргэцүүлэмж бичих зохистой мөчүүдийг өөрсдөө тодорхойлно. Гэсэн хэдий ч, сурагчдын тунгаан бодох, өөрийн үйлдэлд эргэцүүлэл хийх, бичих чадварыг дэмжих үүднээс CAS-ийн зохицуулагч/зөвлөх сурагчдаар тогтмол бичүүлж болно.

Сурагч өөрөө CAS-ийн туршлагын үеэр эргэцүүлэмжийг бий болгох гол мөчүүдийг тодорхойлох нь илүү онцлог юм. Дараах аргууд нь тустай байж болох талтай.

*Сурагчид эргэцүүлэмжийн суурь болох чухал мөчүүдийг сонгодог тохиолдлууд, тухайлбал:*

- шинэ зүйл сурсан, нээж илрүүлсэн агшинд
- аливаа шинэ ур чадварыг эзэмшсэн үедээ
- бэрхшээлтэй тулгарахад
- сэтгэл хөдлөлийг мэдэрсэн үедээ
- тэмдэглэх ёстой ололт амжилтад хүрсэн үедээ

*Сурагчид CAS-ийн аливаа нэг туршлага эсвэл CAS-ийн хэд хэдэн туршлагынхаа явцад эсвэл төгсгөлд нь чухал мөчүүдийг тодорхойлж, боломжит үр дүнгийн талаар ярилцаж, хувийн өсөлт, амжилтыг ухамсарлаж, дараагийн CAS-ийн туршлагаа төлөвлөхийн тулд эргэцүүлдэг.*

*Сурагчид хамтын ойлголтыг олж мэдэхийн тулд үе тэнгийнхэнтэйгээ хамтарч багаар эргэцүүлэх боломжтой.*

*Сурагчид CAS-ийн үргэлжилсэн цуврал туршлагын эхлэлд, явц дунд, төгсгөлд нь эргэцүүлэмж бичнэ. Энэ нь сурагчдад төлөвлөлт, боломж, хүлээлт, бэрхшээл, ахиц дэвшил, хувь хүний өсөлт зэрэг эх үүсвэрүүдийг дүгнэн цэгнэх боломжийг олгодог.*

### **Эргэцүүлэмжийн хэлбэр**

Эргэцүүлэмж нь тоо томшгүй олон хэлбэрээр илэрч болно. CAS-ийн сурагчид хувийн үзэл санаа бүхий үг хэллэгийн хэлбэрийг ялгаж салгах чадвартай байх ёстой бөгөөд тэдний туршлагыг судлан үзэх боломжтой байх ёстой. Жишээлбэл:

- Сурагч явган аялал хийж байхдаа гэрэл зураг авч, эдгээрийг эргэцүүлэмжээ бичихдээ ашиглаж болно.
- Хоёр сурагч хамтарч хүүхдүүдэд хэрхэн тусалж буйгаа дүрсэлсэн дуу зохиож болно.
- Сурагч бүтээлч сэтгэлгээний мэдрэмжийг олж авахын тулд аливаа шүлгийг жүжигчилсэн хэлбэрээр үзүүлж болно.
- Сурагч CAS-ийн туршлагыг нэгтгэн богино хэмжээний видео гаргаж болно.
- Сурагчид багаараа CAS-ийн ажлын зорилтыг харуулсан зурагт хуудас гаргаж болно гэх мэт.

Сурагчийн эргэцүүлэмжийг цогцолбор, богино нийтлэл, эссе, харилцан яриа, шүлэг, хошин шог, жүжигчилсэн тоглолт, захидал, гэрэл зураг, бүжиг эсвэл бусад хэлбэрээр илэрхийлж болно. Сурагч зарим тодорхой эргэцүүлэмжээ нууцлахыг хүсч магадгүй юм. Иймээс сурагчдад CAS-ийн хувийн хэрэгтээ аль эргэцүүлэмжээ оруулах шийдвэрийг үлдээх нь зөв. Сурагчид CAS-ийн хувийн хэрэгтээ CAS хөтөлбөрийн суралцахуйн долоон зорилт тус бүрийг эзэмшсэн эсэх нотолгоог оруулсан байх ёстой.



## Эцсийн хугацаа

CAS хөтөлбөрийн бүх шаардлагыг бүрэн хангаж, төгсөх жилийн 5-р сарын 1-ний өдөр CAS-ийн зохицуулагчид/зөвлөхөд хураалгах ёстой. Хэрэв 5-р сарын 1-ний өдөр хичээлийн бус өдөр таарч байгаа бол дараагийн хичээлийн өдөр нь эцсийн хугацаа болно. Энэ хугацаанд биелүүлээгүй тохиолдолд диплом олгох хугацаа хойшлогдож болзошгүй юм.

CAS-ийн төсөл/туршлага болгоны дараа суралцагчид “Google drive”-т байршуулсан “CAS Portfolio” фолдер доторх өөрийн нэртэй хувийн хэрэгт дараах аргуудаас доод тал нь нэгийг сонгон дүгнэлт, эргэцүүлэмж, нотолгоогоо оруулах ёстой. Үүнд:

1. Зураг (тайлбар бичсэн байх)
2. Тэмдэглэл хөтөлсөн дэвтэр эсвэл Google Doc
3. Блог
4. Дүрс бичлэгийг холбоосоор оруулах
5. Вебсайтад холбоос оруулах
6. Бусад бүтээлч аргаар (CAS-ийн зохицуулагчаас зөвшөөрөл авсан байх)

CAS-ийн ажил үргэлжлэх хугацаанд 7 хоногт ядаж 1 удаа нотолгоо оруулсан байх шаардлагатай. Жишээ нь: 8 долоо хоног үргэлжилсэн үйл ажиллагаанд доод тал нь 8 удаа баримтжуулсан нотолгоо оруулсан байх гэх мэт.

Эргэцүүлэмж бичихдээ үйл ажиллагааныхаа ямар үед /эхэнд, дунд, төгсгөлд/ бичихэд тохиромжтой байгааг харгалзан үзэж дараах асуултуудыг эргэцүүлэн бодож бичнэ.

1. Надад ямар мэдрэмж төрсөн бэ?
2. Би юу ухаарч ойлгосон бэ?
3. Миний явуулсан үйл ажиллагаа ямархуу байсан бэ?
4. Энэ үйл ажиллагаа надад ямар утга учиртай байсан бэ?
5. Миний явуулсан үйл ажиллагаа ямар үнэ цэнэтэй байсан бэ?

6. Энэхүү үйл ажиллагаанаас би юу сурсан, түүнийгээ хэрхэн илүү өргөн цар хүрээгээр ашиглаж болох вэ?

Хэрэв эргэцүүлэмждээ ёс зүйн асуудлыг тусгахаар бол дараах асуултуудыг тунгаан бодож болно. Үүнд:

7. Сайн дурын ажил гэж юу вэ?  
 8. Өөрийнхөө гэр бүлд үзүүлсэн тусламж яагаад тусламжид тооцогддоггүй вэ?  
 9. Өөрийн үзүүлсэн сайн дурын ажлаараа би бусдад тусалж, дэмжиж чадаж байна уу?  
 10. Сайн дурын ажлын хүрээнд биднээс туслалцаа авч буй хүний өмнө би ямар үүрэг хүлээх вэ?  
 11. Сайн дурын ажил хийж байхдаа бусад хүмүүстэй тогтоосон харилцааг би хэрхэн дуусгах вэ?  
 12. Хэрвээ тусламж авч буй хүн тусламж авахыг хүсэхгүй бол яах вэ?

**Эргэцүүлэмжийг ойлгох нь**

Эргэцүүлэмжийг тайлбарлах нэг арга бол эргэцүүлэмж гэж юу болох, юу биш болохыг тодруулах явдал юм. Эргэцүүлэх үйл явцын талаарх хэлэлцүүлэг эхлүүлэхэд тустай арга нь суралцагчид үе тэнгийнхэнтэйгээ хамтран ажиллах ба өөрсдийн харьцуулах хүснэгтийг гаргах явдал юм. Энэ хүснэгтэд суралцагчид юу жагсааж хэлэлцэж болох жишээг харуулав.

Эргэцүүлэмж бол:	Эргэцүүлэмж биш:
<input type="checkbox"/> үнэн шударга <input type="checkbox"/> хувийн <input type="checkbox"/> олон хэлбэрээр илэрхийлэгддэг <input type="checkbox"/> заримдаа хэцүү <input type="checkbox"/> заримдаа амархан <input type="checkbox"/> заримдаа бүтээлч <input type="checkbox"/> мэдлэгээ хөгжүүлсэн	<input type="checkbox"/> хүчилсэн <input type="checkbox"/> зөв эсвэл буруу <input type="checkbox"/> сайн эсвэл муу <input type="checkbox"/> оноо, дүн тавьсан <input type="checkbox"/> хэцүү <input type="checkbox"/> бусдын хэлснийг хуулж бичих <input type="checkbox"/> таамаг

<input type="checkbox"/> суралцахад шаардлагатай <input type="checkbox"/> юу хийсэн, юу мэдэрсэн <input type="checkbox"/> гэнэтийн <input type="checkbox"/> төлөвлөхөд тустай <input type="checkbox"/> ганцаар эсвэл бусадтай хамт хийсэн <input type="checkbox"/> үзэл бодол, мэдрэмж, санааны талаар	<input type="checkbox"/> бусдаар шүүмжлүүлсэн <input type="checkbox"/> юу болсон талаар дүгнэлт <input type="checkbox"/> бусдад таалагдахын тулд <input type="checkbox"/> цаг нөхцөөсөн <input type="checkbox"/> дан бичиглэл хэлбэрээр <input type="checkbox"/> дан хэлэлцүүлэг хэлбэрээр <input type="checkbox"/> багшаар зааварлуулсан
---	---

### **CAS-ийн төсөл**

“CAS-ийн төсөл гэдэг нь сурагчдыг CAS-ийн нэг буюу хэд хэдэн бүтээлч ажил, бие махбодийг хөгжүүлэх ажил, сайн дурын ажилд татан оролцуулах, хамтарсан, сайн тооцоолон төлөвлөсөн цуврал CAS-ийн туршлагуудыг хэлнэ. CAS-ийн сурагч CAS хөтөлбөрийнхөө явцад дор хаяж нэг CAS-ийн төсөлд оролцох ёстой.” (Нийгэмд тустай ажил хичээлийн гарын авлага, 2017 он, хуудас 24)

CAS-ийн төсөл нь сурагчдыг санаачилга гаргах, шаргуу хичээнгүй байдал харуулахыг шаарддаг бөгөөд хамтын ажиллагаа, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах зэрэг чадваруудыг хөгжүүлдэг. CAS-ийн төсөл дээр сурагчид багаар эсвэл илүү өргөн хүрээний нийгмийн гишүүдтэй хамтран ажиллана. Сурагчид CAS-ийн төсөл дээр CAS-ийн төслийн нэг хэсэгт эсвэл бүхэлд нь үүрэг хүлээх, эсвэл санаачилга гаргах боломжтой болдог. Хамтран ажиллах нь сурагчдад CAS-ийн төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад хувийн сонирхол, ур чадвар, авъяас чадвараа бататгах, нэгтгэх боломжийг олгодог. Бүх CAS-ийн төслүүд бүх шаардлагыг хангаж буй эсэхийг баталгаажуулахын тулд хэрэгжүүлэлтийн хүрээнд CAS-ийн таван үе шатыг ашиглах ёстой. CAS-ийн төсөл нь CAS-ийн аль нэг хэлхээ эсвэл хоёр эсвэл бүх гурван хэлхээг нэгтгэх боломжтой.

CAS төслийн хамрах хүрээ, чиглэлийг хязгаарлахгүйгээр өшөө илүү олон санааг бий болгоход туслах дараах жишээг үзүүлэв.

- *Бүтээлч ажил: Сурагчид багаар урлагийн бүтээл төлөвлөх, загварчлах, бүтээх.*
- *Бие мах бодийг хөгжүүлэх ажил: Сурагчид спортын баг, бэлтгэл зэргийг зохион байгуулах ба оролцох, бусад багийн эсрэг тоглох.*
- *Сайн дурын ажил: Сурагчид хэрэгцээтэй хүмүүст зориулж хичээл заах, сургалт явуулах.*
- *Бүтээлч ажил, бие махбодийг хөгжүүлэх ажил, сайн дурын ажил: Сурагчид ахмадуудын асрамжийн газарт бүжгэн жүжиг тоглодог.*

Төлөвлөхөөс эхлүүлээд дуусах хүртэл аливаа CAS-ийн төсөлд дор хаяж нэг сарын хугацаа зарцуулах шаардлагатай. CAS-ийн туршлагын явцад сурагчид CAS-ийн төслийн туршлагаа эргэцүүлэх ёстой.

### **Чиглүүлэх асуултууд**

Дараах асуултуудад хариулснаар CAS-ийн нэг хэсэг болоход бэлэн эсэхээ мэдэж авах боломжтой.

1. *Энэ туршлага нь намайг шинэ зүйл хийхэд минь туслах уу?*
2. *Миний хийх гэж байгаа зүйл бодит зүйл мөн үү?*
3. *Энэ туршлага нь надад болон бусдад ямар зорилт үзүүлэх вэ?*
4. *Энэ үйл ажиллагаанд хамрагдсанаар би юу сурах вэ?*
5. *Энэхүү үйл ажиллагаа нь бусад хүмүүст хэрхэн нөлөөлөх вэ?*
6. *Энэ үйл ажиллагааны туршид би юуг сурах вэ?*
7. *Миний зөвлөгч хэн байх вэ?*
8. *Энэ туршлага/төсөлд CAS-ийн гурван хэлхээнээс аль нь холбогдож байна вэ?*  
\_\_\_C \_\_\_A \_\_\_S
9. *Энэ туршлагаас/төслөөс ямар үр дүн гарсан бэ? \_\_\_1 \_\_\_2 \_\_\_3 \_\_\_4 \_\_\_5 \_\_\_6 \_\_\_7*

## CAS-ийн туршлага болон төслүүдийн жишээ

CAS ба Дипломын хөтөлбөрийн сурагчид CAS болон Дипломын хөтөлбөрт сурч буй төрөл бүрийн хичээлийн бүлгүүдийн хоорондын уялдаа холбоог харах боломжтой байх ёстой. Доорх CAS-ийн туршлагууд болон төслүүдийг Дипломын хөтөлбөрийн бүлгүүдтэй хэрхэн уялдуулж болох талаар харуулав:

CAS-ийн туршлага ба төслүүдийн жишээ		C	A	S
Group 1 (Хэл ба уран зохиол)	Хараагүй хүмүүст зориулсан сонсдог ном гаргах	*		*
Group 2 (Хэлний мэдлэгийг сайжруулах)	Хэлээ сайжруулахыг хүссэн суралцагчдад зориулсан хичээл зохион явуулах	*		*
Group 3 (Хүн нийгэм)	Ахмадын асрамжийн газарт амьдардаг ахмадаас тэдний түүхийг сонсож, тэмдэглэж авах, ном бичих	*		*
Group 4 (Байгалийн шинжлэх ухаан)	Бага насны сурагчдад зориулсан одон орон судлалын клуб байгуулах	*	*	*
Group 5 (Математик)	Тухайн газар дахь хандивын төвд санхүүгийн дэмжлэг өгөх			*
Group 6 (Урлаг)	Жижиг эсвэл бүжгийн хичээлд хамрагдаж, сайн үйлсийн аянд зориулж театрчилсан үзүүлбэр үзүүлэх	*	*	

*\*CAS-ийн туршлага ба төслүүдийн нэмэлт жишээ*

Сайн дурын ажил	C	A	S
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэлж сурахыг заах	*	*	*
Софтболын баг дасгалжуулах	*	*	*
Бага насны сурагчдад гитар тоглохыг заах	*		*
Хүүхдүүдтэй хамт ханын зураг зурах	*	*	*
Явган хөгжмийн хамтлагт бүжиг дэглэх	*	*	
Ууланд авиралтын аяныг ахлах	*	*	*
Ахмадын асрамжийн газарт бүжгийн тоглолт явуулах	*	*	*
Бусад сургуулиудтай хөгжмийн болон урлагийн чадваруудаа солилцох	*		*

## **CAS хөтөлбөрийн суралцагчийн CAS-ийн хувийн хэрэг**

Бүх суралцагчид CAS хөтөлбөрийн суралцахуйн 7 зорилтод хүрсэн эсэхээ нотлохын тулд CAS-ийн хувийн хэрэгтэй байх хэрэгтэй ба үүнээс суралцагч АйБи хөтөлбөрийн суралцагчийн эзэмшсэн байх 10 шинж чанарыг өөртөө хэрхэн хөгжүүлсэн байдал нь харагдах юм. CAS-ийн хувийн хэрэг нь дараах зүйлсийг агуулсан байна:

1. CAS-ийн туршлагын төлөвлөгөө
2. CAS-ийн туршлагын бодит эргэцүүлэмж
3. Суралцагч нь CAS хөтөлбөрийн суралцахуйн 7 зорилтод хүрсэн нотолгоо
4. Суралцагчийн төслийн бичиг баримт

*Миний CAS хөтөлбөрийн суралцагчийн CAS-ийн хувийн хэрэг ямар загвартай байх вэ?*

CAS хөтөлбөрийн суралцагчийн CAS-ийн хувийн хэрэг нь А4 хэмжээтэй, ямар ч загвартай байж болох ба үүнд веб блог, хувийн тэмдэглэл, эргэцүүлэмж, бичлэг, зураг зэрэг бусад нотолгоо багтана.

## **CAS-ийн ярилцлага**

Суралцагчдын явцыг хэлэлцэж, зөвлөн туслах зорилгоор CAS-ийн зохицуулагч/зөвлөх суралцагч бүртэй багадаа гурван ярилцлага хийнэ. Дипломын хөтөлбөрийн эхний жилд хоёр удаа ярилцлага хийж, сүүлийн жилд нэг удаа ярилцлага хийгдэнэ. Эдгээр ярилцлагын санал сэтгэгдлүүдийг CAS-ийн зохицуулагч/зөвлөх бичиж хадгална.

Ярилцлагуудыг CAS-ын явцын хуудас дээр эсвэл дижитал бүртгэл дээр тэмдэглэн баримтжуулна. Хэрэв асуудал үүсвэл, ялангуяа CAS хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал гарвал аль болох эрт үед нь тэмдэглэж, зохих арга хэмжээг авах шаардлагатай болно. Гурав дахь ярилцлага нь сурагчийн CAS хөтөлбөрт хамрагдсан байдал, CAS хөтөлбөрийн суралцахуйн долоон зорилтод хүрсэн эсэх талаар дүгнэн ярилцах эцсийн хэлэлцүүлэг юм. Энэ үед CAS

хөтөлбөрийн гүйцэтгэлийн маягт эсвэл дижитал бүртгэл гэх мэт бусад тохиромжтой бүртгэлийн аргыг ашиглана.

CAS-ийн зохицуулагч нь Дипломын хөтөлбөрийн журмын гарын авлагад заасны дагуу сурагч бүрийн гүйцэтгэлийн шийдвэрийг IBIS дээр бүртгэнэ.

### **Анхны ярилцлага**

Энэхүү ярилцлагыг Дипломын хөтөлбөрийн эхэнд хийнэ. Энэхүү ярилцлагаар CAS-ийн зохицуулагч/зөвлөх нь суралцагчдыг CAS-д тавигдах шаардлагыг ойлгосон эсэхийг нягталж, CAS хөтөлбөрийн суралцахуйн долоон зорилтыг тайлбарлаж, эдгээр зорилтод сурагч хэрхэн хүрч болохыг тайлбарлаж, сурагчийн сонирхол ба CAS-ийн ажлын талаарх санаа бодлыг нь хэлэлцэж, CAS хөтөлбөрийн суралцагчийн CAS-ийн хувийн хэрэг ямар хэлбэр загвартай байх ёстойг тодорхойлж, CAS-ийн ажлын үе шатуудыг хянана. Хэрэв сурагчид CAS-ийн талаар аль хэдийн мэдэж байвал энэхүү CAS-ийн ярилцлага нь тэдний ойлголтыг баталгаажуулах ба аливаа төлөвлөгөө, санаануудад нь туслах боломжийг олгох юм.

### **Хоёр дахь ярилцлага**

Энэхүү ярилцлагыг ихэвчлэн Дипломын хөтөлбөрийн эхний жилийн төгсгөлд зохион байгуулдаг. Ярилцлагын гол зорилго нь сурагчийн CAS дахь ахиц амжилтыг үнэлэхэд оршино. Сурагчид CAS-ийн олон ажлыг хэрэгжүүлж, CAS хөтөлбөрийн суралцахуйн долоон зорилтод хүрч байгаа нь энэхүү ярилцлагын бодит ач холбогдол юм. Энэ шатанд сурагчид CAS-ийн төслийг хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж байх болно. Сурагчийн CAS-ийн хувийн хэргийг энэхүү ярилцлагад ашиглаж, суралцахуйн долоон зорилтын аль нэгэнд нь хүрсэн зэрэг нотлох баримтуудыг хянаж шалгана.

### **Сүүлийн ярилцлага**

Энэ бол CAS-ийн эцсийн ярилцлага юм. Дипломын хөтөлбөр дуусахаас өмнөхөн явагдана. Энэхүү ярилцлагад сурагч нь CAS хөтөлбөрийн суралцахуйн зорилтод хэрхэн хүрсэн эсэхээ тоймлон харуулна. Нэмж дурдахад тэд CAS хөтөлбөрийнхөө

талаар ярилцаж, дүгнэн цэгнэж, хувь хүний өсөлт хөгжилтийн талаар эргэцүүлнэ. Сурагчийн CAS-ийн хувийн хэргийг энэхүү ярилцлагад ашиглана. Энэхүү гурав дахь ярилцлага нь сурагчдын хувийн туршлага дээр үндэслэн ирээдүйн CAS хөтөлбөрийн суралцагчдад зориулсан CAS хөтөлбөрийг боловсруулах талаар ярилцах боломжийг олгох юм.

### **CAS хөтөлбөрийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг**

***CAS хөтөлбөрийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид нь дараах байдлаар бусдад хүндэтгэлтэй, хүлээцтэй байх үүрэгтэй. Үүнд:***

1. CAS бол АйБи хөтөлбөрийн чухал хэсэг гэдгийг суралцагчид ойлгуулж, дэмжих;
2. Суралцагч хэзээ CAS-ийн үйл ажиллагаа зохион байгуулж буйг мэдэж, эргэцүүлэмж бичиж буй эсэхэд хяналт тавих;
3. Суралцагчдын сайн сайхны төлөө аливаа асуудлыг хэлэлцэх, зөв шийдэл олоход багш нартай хамтран ажиллах;
4. Асуулт байвал Суралцагчийн CAS-ийн зохицуулагчтай/зөвлөхтэй холбогдож ярилцах;
5. Сургуулийн бусад эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтнуудад өөрийн үг, үйл хөдлөлөөр үлгэрлэн манай сургуулийн ёс зүйн хэм хэмжээг дэмжих;
6. Өөрийн хүүхдийг олон нийтийн газарт биеэ зөв, соёлтой авч явах дадалд сургаснаар бусадтай зөрчилдөхөд хүргэхээс сэргийлэх;
7. Сургуулиас зохион байгуулж буй эсвэл хичээлээс гадуурх бүхий л үйл ажиллагаанд суралцагчдад үр ашигтай зөвлөгөө өгөх;
8. Сургуулийн орчин тойронд хог хаяхгүй байх гэх мэт сургуулийн орчинд хүндэтгэлтэй хандах.





## SHINE UE SCHOOL

Unesco-12, Khoroo 1,  
Sukhbaatar district, Ulaanbaatar 14220  
Tel: 70128044; 328044  
E-mail: [info@shineue.edu.mn](mailto:info@shineue.edu.mn)  
Website: <http://www.shineue.edu.mn>



International Baccalaureate®  
Baccalauréat International  
Bachillerato Internacional

### CAS хөтөлбөрийн суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай хийх гэрээ

Миний бие \_\_\_\_\_ “Шинэ үе” сургуулийн  
(эцэг эхийн нэр)

**CAS-ийн гарын авлагыг уншиж танилцаад өөрийн хүүхэд**

\_\_\_\_\_ -ийг CAS-ийн үйл ажиллагаанд  
(суралцагчийн нэр)

**хамрагдахыг нь зөвшөөрч байна.**

1. Миний хүүхэд CAS-ийн хянагчийн хяналт дор байхыг нь зөвшөөрч байна.
2. CAS-ийн үйл ажиллагаа нь 18 сарын турш үргэлжлэхийг нь ойлгож байна.
3. Хүүхдээ цаашид дэмжиж ажиллах болно.
4. CAS-ийн зохицуулагчтай ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд уулзаж, зөвлөгөө авна.
5. Шинэ үе сургууль нь ямар нэгэн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй ба харин тусламж, дэмжлэг, заавар зэргийг өгөхийг нь ойлгож байна.
6. Миний хүүхэд “Шинэ үе” сургуулиас санхүүжүүлээгүй ямар нэгэн үйл ажиллагаанд хамрагдах бол энэ үйл ажиллагаатай холбоотой бүхий л үүрэг хариуцлага, хүүхдийнхээ аюулгүй байдлыг эцэг эхийн зүгээс хариуцна.
7. Сургуулиас гадуурх үйл ажиллагаанд оролцож байхдаа миний хүүхэд ямар нэгэн гэмтэл авсан эсвэл өвдсөн тохиолдолд эцэг эхийн зүгээс анхны тусламжийг үзүүлнэ.
8. Үйл ажиллагаанд хамрагдсаныг нотлох гэрэл зураг авах эсвэл дүрс бичлэг хийхийг нь зөвшөөрч байна.

Энэхүү гэрээний нөхцөлийг ойлгож, зөвшөөрч байна.

\_\_\_\_\_

Овог нэр

\_\_\_\_\_

Он сар өдөр

\_\_\_\_\_

Гарын үсэг

\_\_\_\_\_

Утас

\_\_\_\_\_

Цахим шуудан



**SHINE UE SCHOOL**  
 Unesco-12, Khoroo 1,  
 Sukhbaatar district, Ulaanbaatar 14220  
 Tel: 70128044; 328044  
 E-mail: [info@shineue.edu.mn](mailto:info@shineue.edu.mn)  
 Website: <http://www.shineue.edu.mn>



**International Baccalaureate®**  
**Baccalauréat International**  
**Bachillerato Internacional**

### CAS REPORTING TIMELINES

Year and phase	Expectations	Student requirements	Evidence
<b>DP year 1 Term 1</b>	CAS planning and completion of proposal	Students discuss proposals with CAS coordinator/adviser and parents.	Proposal approved and signed by student, parents and CAS coordinator/adviser
<b>DP year 1 End of term 1</b>	CAS experiences begun	Students have engaged in CAS experiences.	Completion of reflections and gathering of evidence
	CAS reporting	Based on the meetings of weekly basis	Progress comment on term 1 academic report
<b>DP year 1 End of term 2</b>	Ongoing CAS experiences	Students show evidence of planning and progress on the project.	Completion of reflections and gathering of evidence
	Some CAS experiences completed	Some CAS experiences are finalized, including reflections, evidence and supervisor reports if available.	Completion of reflections and gathering of evidence
	CAS reporting	Students take the initial interview with the CAS coordinator/adviser to discuss progress. Coordinator/adviser and student complete CAS checklist.	Progress comment on semester 1 academic report
<b>DP year 1 End of term 3</b>	Project under way	Students show evidence of planning and progress on the project.	Completion of reflections and gathering of evidence
	Further CAS experiences completed	Further CAS experiences are finalized, including reflections, evidence and supervisor reports if available.	Completion of reflections and gathering of evidence
	CAS reporting	Students take the interim interview with the CAS coordinator/adviser to discuss progress. Coordinator/adviser and student complete CAS checklist.	Progress comment on final term of the year academic report; letter home to parents if unsatisfactory
<b>DP year 2 End of term 1</b>	Project completed	Project is finalized, including reflections, evidence and supervisor report if available.	Completion of reflections and gathering of evidence
<b>DP year 2 End of term 2</b>	Project and most CAS experiences completed; progress evident on final CAS experiences	Project and most CAS experiences are finalized. Significant progress on remaining CAS experiences is evident.	Progress comment on semester 1 term 1 academic report; letter home to parents if unsatisfactory

<b>DP year 2 In term 3</b>	Final CAS experiences and projects completed	CAS experiences and projects are finalized, including reflections, evidence and supervisor reports if available.	Completion of reflections and gathering of evidence
	Final CAS reporting	Students take the final interview with the CAS coordinator/adviser to discuss progress. Coordinator/adviser and student complete CAS checklist.  CAS adviser reports on CAS completion.	Completion comment on semester 1 academic report; letter to parents if unsatisfactory
<b>DP year 2 End of the final term</b>	Official CAS sign-off	CAS project and all CAS experiences are complete, including: all reflections, all evidence and supervisor reports where available.  Note: CAS coordinator/adviser signs off CAS portfolio using the CAS checklist. The CAS coordinator compiles a list of students whose portfolios are unsatisfactory and follows up until complete.	Completion of reflections and gathering of evidence; letter home to parents again if student CAS portfolio is unsatisfactory, with warning about IB Diploma now being “at risk”.



**SHINE UE SCHOOL**

Unesco street-12, Khoroo 1, Sukhbaatar district, Ulaanbaatar 14220

Tel: 70128044; 328044

E-mail: [info@shineue.edu.mn](mailto:info@shineue.edu.mn)

Website: <http://www.shineue.edu.mn>



International Baccalaureate®  
Baccalauréat International  
Bachillerato Internacional

**A STUDENT CHECKLIST FOR CAS**

Creativity	Activity	Service
Exploring and extending ideas leading to an original or interpretive product or performance	Physical exertion contributing to a healthy lifestyle	Collaborative and reciprocal community engagement in response to an authentic need
My CAS programme	Y/N?	Notes Date
Evidence of planning of a CAS programme		
Regular commitment over at least 18 months to CAS		
Understanding and ability to use the CAS stages when planning CAS experiences		
Balance between creativity, activity and service		
At least one planned project undertaken over at least one month		
Evidence of achieving all seven learning outcomes		
Evidence of identification of strengths and areas for personal growth (LO1)		
Evidence of undertaking new challenges and developing new skills in the process (LO2)		
Evidence of initiating and planning a CAS experience (LO3)		
Evidence of commitment and perseverance in CAS experiences (LO4)		

Evidence of demonstrating the skills and recognizing the benefits of working collaboratively (LO5)		
Evidence of engagement with issues of global significance (LO6)		
Evidence of recognizing and considering the ethics of choices and actions (LO7)		
Reflections completed on significant CAS experiences		
Supervisor reports supplied where necessary		
CAS interview 1 completed		
CAS interview 2 completed		
CAS interview 3 completed		
CAS portfolio completed		

Name of student:



**SHINE UE SCHOOL**

Unesco-12, Khoroo 1, Sukhbaatar district, Ulaanbaatar 14220

Tel: 70128044; 328044

E-mail: [info@shineue.edu.mn](mailto:info@shineue.edu.mn)

Website: <http://www.shineue.edu.mn>



International Baccalaureate®  
Baccalauréat International  
Bachillerato Internacional

**CAS project form**

Student project leader(s)	
Members	
Title of project	
Focus of project	
How we are following the CAS stages	For each CAS stage, describe either what has been done or what you plan to do.
● Investigation	
● Preparation	
● Action	
● Reflection	
● Demonstration	
Name of organization the project is organized with or for, if applicable	

Contact person at organization, contact phone and email, if applicable	
Teacher or other external supervisor, if applicable	
Anticipated dates of CAS project	
Risk assessment required?	Yes/No Risk assessment completed? Yes/No
Student signatures	
CAS supervisor/adviser signature/date	
Principal signature (if required)/date	

Name of student:



## SHINE UE SCHOOL

Unesco-12, Khoroo 1,  
Sukhbaatar district, Ulaanbaatar 14220  
Tel: 70128044; 328044  
E-mail: [info@shineue.edu.mn](mailto:info@shineue.edu.mn)  
Website: <http://www.shineue.edu.mn>



International Baccalaureate®  
Baccalauréat International  
Bachillerato Internacional

## CAS Portfolio Checklist

The CAS portfolio is a requirement of the IB Diploma Programme, but it is increasingly becoming a document that is used beyond its originally intended purpose. Many students are using the CAS portfolio as a presentation document for proof of past performance and future job placements.

Your completed **CAS program** must include:

- a separate CAS Planner for each one of the three components: Creativity, Action and Service
- a balanced program – devote 2 to 3 hours each week in years DP1 and DP2
- a separate CAS Diary and CAS Reflection Form for each activity undertaken
- new challenges or extensions to familiar activities
- evidence of planning in collaboration with others on at least one project
- an activity that integrates two of the three program components: Creativity, Action and Service (state how this activity crosses over 2 of the CAS components)
- an activity engaging issues of global importance
- some evidence of thinking about ethical issues
- some evidence of development of new skills
- thoughtful reflections on your experiences
- a CAS Summary Log that lists each of your CAS activities and the outcomes achieved in each activity
- a CAS Summative Reflection Form that describes your participation in the CAS program including: 1) personal development 2) benefits to others 3) how you have achieved each of the seven required learning outcomes using specific examples from your personal CAS experience

Your **CAS Portfolio** will:

- be presented in a business like fashion
- be in booklet form
- be bound with a clear plastic front covering through which can be seen an attractive title page on which your name is clearly indicated
- use dividers to create and identify 5 sections (Introduction, Creativity, Action, Service, Summary)
- have all required signatures complete (CAS Coordinator/Adviser, Project/Activity Leaders)
- be neatly typed
- be assessed as a presentation document
- be completed in all aspects (refer to CAS forms)
- be handed in to the IB Coordinator by May 1 of your DP2 year

As you are aware, marks will be deducted if you have not completed the CAS portfolio in the manner as described above, and your final grade will be adjusted accordingly.



## Ашигласан материалын жагсаалт

Terbish, K. (2019). “IB Parents Handbook” 2019. Retrieved February 23, 2021, from <https://drive.google.com/file/d/10CyGp1i9EUptfZO--hq0sYzAegK4r3ol/view?usp=sharing>

Programme resource centre (2021) & Creativity, activity, service teacher support material (2017). “CAS reporting timelines” example. Retrieved February 23, 2021, from [https://ibpublishing.ibo.org/server2/rest/app/tsm.xql?doc=d\\_0\\_casxx\\_tsm\\_1504\\_2\\_e&part=2&chapter=9](https://ibpublishing.ibo.org/server2/rest/app/tsm.xql?doc=d_0_casxx_tsm_1504_2_e&part=2&chapter=9)

The CAS strands. Retrieved February 24, 2021, from [https://www.google.com/search?q=cas%2Bstages%2Bimage&client=ms-android-samsung-gj-rev1&prmd=ivn&sxsrf=ALeKk00QArmonnkL6-o0OV2jJLBJTzrWNO%3A1614128207191&source=lnms&tbm=isch&sa=X&ved=2ahUKEwj\\_r\\_KSTqIHvAhWnw4sBHVv8CR0Q\\_AUoAXoECA0QAQ&biw=360&bih=512&dpr=1.5#imgcr=ulc3aOdvDQseWM](https://www.google.com/search?q=cas%2Bstages%2Bimage&client=ms-android-samsung-gj-rev1&prmd=ivn&sxsrf=ALeKk00QArmonnkL6-o0OV2jJLBJTzrWNO%3A1614128207191&source=lnms&tbm=isch&sa=X&ved=2ahUKEwj_r_KSTqIHvAhWnw4sBHVv8CR0Q_AUoAXoECA0QAQ&biw=360&bih=512&dpr=1.5#imgcr=ulc3aOdvDQseWM)

Programme resource centre (2021) & Creativity, activity, service teacher support material (2017). “A student checklist for CAS”. Retrieved February 23, 2021, from [https://ibpublishing.ibo.org/server2/rest/app/tsm.xql?doc=d\\_0\\_casxx\\_tsm\\_1504\\_2\\_e&part=2&chapter=7](https://ibpublishing.ibo.org/server2/rest/app/tsm.xql?doc=d_0_casxx_tsm_1504_2_e&part=2&chapter=7)

Programme resource centre (2021) & Creativity, activity, service teacher support material (2017). “CAS project form”. Retrieved February 23, 2021, from [https://ibpublishing.ibo.org/server2/rest/app/tsm.xql?doc=d\\_0\\_casxx\\_tsm\\_1504\\_2\\_e&part=2&chapter=11](https://ibpublishing.ibo.org/server2/rest/app/tsm.xql?doc=d_0_casxx_tsm_1504_2_e&part=2&chapter=11)

Google search (2020). “CAS portfolio checklist”. Retrieved February 24, 2021, from <http://chc.wrdsb.ca/files/2014/08/CAS-Portfolio-Checklist.doc>

Google search. (2021, February 24). “CAS stages image”. Retrieved February 24, 2021, from [https://www.google.com/search?q=CAS%2Bexperiences&client=ms-android-samsung-gj-rev1&prmd=ivn&sxsrf=ALeKk03S0svsoLYk5Nhn\\_ZUxrIf9ai8IXg%3A1614127816337&source=lnms&tbm=isch&sa=X&ved=2ahUKEwjWhPXYPoHvAhV5xIsBHf-BBNUQ\\_AUoAXoECA4QAQ&biw=360&bih=512#imgcr=-zIdwMX3K3cJcM](https://www.google.com/search?q=CAS%2Bexperiences&client=ms-android-samsung-gj-rev1&prmd=ivn&sxsrf=ALeKk03S0svsoLYk5Nhn_ZUxrIf9ai8IXg%3A1614127816337&source=lnms&tbm=isch&sa=X&ved=2ahUKEwjWhPXYPoHvAhV5xIsBHf-BBNUQ_AUoAXoECA4QAQ&biw=360&bih=512#imgcr=-zIdwMX3K3cJcM)